



МОНГОЛ УЛААСНЫ ГЭРЭЛТ  
ТЭГШЛЭГ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН  
ТАНАА

2020-04-24

01/304


Санал хүргүүлэх тухай

Батлан хамгаалахын сайдын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/80 дугаар тушаалаар "Улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх журам", "Улсын агаарын хөлгөөр тусгай үүргийн нислэг үйлдэх журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын яам, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 390/180 дугаар тушаалаар батлагдсан "Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах хамтарсан журам", "Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журам"-ыг хамтран боловсруулах саналтай байна.

Энэ журмын төсөл болон "Улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх журам", "Улсын агаарын хөлгөөр тусгай үүргийн нислэг үйлдэх журам"-ыг хүргүүлэв.

Хавсралт: 9 хуудастай.

ХЯНАЛТТАЙ ХУВЬ  
2020-05-12  
ААЧБХ



КОМАНДЛАГЧ  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

*О.ЭНХБАЯР*

О.ЭНХБАЯР

*Алтанцол*  
*Булзах*

*Е.Бүжигбаян-г*

*Хамтран ажиллах*

*Р.М.М. 12/5*

*12/29*

Г.Монголхуягт

*Хардвард өгөгдсүүдэд ицмийг  
бичигдүүлэх, хэрэгшилж 137.03013  
болгож өгнөх! 2020.04.30*

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
03 дугаар сарын 30-ны өдрийн 780 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

УЛСЫН АГААРЫН ХӨЛГӨӨР ОНЦГОЙ ҮҮРГИЙН  
НИСЛЭГ ҮЙЛДЭХ ЖУРАМ

Нэг Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэхэд оролцогч байгууллагуудын үүрэг болон нислэгийн захиалга, зөвшөөрөл олгох, нисэх баг, түүнд тавигдах шаардлага, нислэг үйлдэх агаарын хөлөг, түүнийг нислэгт бэлтгэх, хамгаалах, зорчигч, ачаа тээш, нисэх буудлын үйлчилгээтэй холбоотой харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журам нь онцгой үүргийн нислэг үйлдэх улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагын баримтлах үндсэн баримт бичиг болно.

1.3. Улсын агаарын хөлгийн онцгой үүргийн нислэг гэж Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нислэгийг ойлгоно

1.4. Энэхүү журамд Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтнууд болон гадаад улсын дээд хэмжээний зочин төлөөлөгчид иргэний нисэхийн агаарын хөлгөөр зорчихтой холбогдсон зохицуулалт хамаарахгүй.

1.5. Гадаад улсад улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх бол Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад эрх зүйн актыг мөрдлөг болгоно

Хоёр Нислэгийн захиалга

2.1. Захиалагч нь онцгой үүргийн нислэгийн захиалгыг орон нутгийн агаарын зайд нислэг эхлэхээс ажлын 2 хоног, олон улсын агаарын орон зайд нислэг эхлэхээс ажлын 14 хоногийн өмнө Зэвсэгт хүчний Жанжин штабт албан бичгээр хүргүүлнэ.

2.2. ЗХЖШ-ын дарга онцгой үүргийн нислэгийн захиалгыг хянаж холбогдох шийдвэрийг Агаарийн цэргийн командлалд хүргүүлнэ.

2.3. Онцгой үүргийн нислэгийн захиалга хүлээн авсан улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллага нь орон нутгийн агаарын зайд нислэг үйлдэх бол энэ тухай 48 цагийн дотор ИНЕГ /Иргэний нисэхийн Ерөнхий газар/-т мэдэгдэнэ.

2.4. Захиалга авсан улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллага /гүйцэтгэгч/ нь улсын агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгийг хариуцан зохион байгуулна.

Гурав Нислэгийн зөвшөөрөл олгох

3.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч нь захиалагч байгууллагын хүсэлтийг үндэслэн улсын агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгт бэлтгүүлэх мэргэжилтэнг томилж, нислэгийн удирдамжийг боловсруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар баталгаажуулна.

ХЯНАЛТТАЙ ХУВЬ  
2020-05-12

ААНСХ

5.5 Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас томилогдсон мэргэжилтэн болон эрх бүхий байцаагч /шалгагч/-нислэгчийн хяналтан дор агаарын хөлгийн нислэг-техникийн үзүүлэлтүүдийг шалгах зорилгоор нисэх баг нь тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааврын дагуу 30 минутаас багагүй хугацаагаар шалгах нислэгийг үйлдэнэ.

5.6 Шалгах нислэгээр агаарын хөлгийн нислэг-техникийн үзүүлэлтүүд хэвийн тохиолдолд 3 хувь акт үйлдэн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчаар баталгаажуулж, 1 хувийг Төрийн тусгай хамгаалалтын газарт хүргүүлнэ.

5.7 Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас акт баталгаажсанаар тухайн агаарын хөлгийг онцгой үүргийн нислэгт бэлэн болсонд тооцно.

5.8 Нислэг үйлдэх агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх ажиллагаа болон шатахууны шинжилгээний дүн болон сорьцод Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан хяналт тавих бөгөөд шатахууны дээжийг тусгайлан саванд авч лавдан, уг нислэг дуусах хүртэл хадгална.

#### Зургаа. Нисэх багт тавигдах шаардлага

6.1 Нислэг үйлдэж байгаа нисэх багийн дарга нь өдөр шөнийн цагт, цаг агаарын ердийн болон хүндэрсэн нөхцөлд зөвшөөрөгдсөн хязгаарлалтыг зөрчиж нислэг үйлдэхийг хориглоно.

6.2 Нислэг үйлдэж буй нисэх багийн гишүүд нь нислэгийн аюулгүй байдлыг хангах үүднээс хөөрөлтийн үеийн жинг тогтоогдсон хамгийн их хэмжээний 80 хувиас хэтрүүлэхийг хориглоно.

6.3 Нислэг үйлдэж буй нисэх багт хоногт дунджаар 6-8 цагийн нислэг үйлдэхийг зөвшөөрнө.

6.4 Нислэг гүйцэтгэхээр томилогдсон нисэх багийн гишүүд нислэг үйлдэхээс өмнө 8 цагаас багагүй хугацаанд унтаж амарсан байна.

6.5 Нислэг үйлдэхээр томилогдсон нисэх багийн гишүүд /бүрэлдэхүүн/-ийг нислэг эхлэхээс өмнө 48 цагийн дотор өөр ажилд даажардуулан томилох болон хойшлуулшгүй онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд тусгай үүрэг, ажиллагаанд татан оролцуулахгүй.

#### Долоо. Нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах

7.1 Нислэгийн батлагдсан чиглэл, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тохиолдолд захиалагч байгууллага нь нислэг эхлэхээс 2-оос доошгүй цагийн өмнө энэ тухайгаа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал болон ИНЕГ-т мэдэгдэнэ.

7.2 Нислэг үйлдэж буй нисэх баг нь нислэгийн хөдөлгөөний холбогдох журам, зааврын дагуу хөөрөлт буултын цаг, агаарын хөлгийн байрлал, нислэгтэй холбоотой бусад мэдээллийг ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтанд мэдээлнэ.



Орон нутагт харуул хамгаалалтыг тухайн орон нутгийн тагнуул, цагдаагийн байгууллагууд хамтарч Төрийн тусгай хамгаалалтын газрын хяналтан дор гүйцэтгэнэ.

10.4 Онцгой үүргийн нислэг үйлдэх агаарын хөлөгт нэвтрэх албан тушаалтан иргэн нь зөвхөн төрийн тусгай хамгаалалтын газрын зөвшөөрлөөр нэвтэрнэ.

10.5 Шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь ЗХЖШ-ын даргын шийдвэрийг үндэслэн байлдааны жижүүрлэлтийн хүч хэрэгслийг нэмэгдүүлж, агаарт жижүүрлэлт үйлдэх болон агаарын хамгаалалтыг зохион байгуулна.

Арван нэг Төлбөр тооцоо, хангалт

11.1 Зорчигч үйлчлүүлэгчид болон нисэх багийн гишүүдийг баталгаат хүнсний бүтээгдэхүүнээр хангах асуудлыг захиалагч, хүнсний эрүүл ахуйд хяналт тавих асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцна.

11.2 Нислэгтэй холбогдсон төлбөр, тооцоог тухайн нислэгийг захиалагч тал хариуцна.

Арван хоёр Нислэг дууссанд тооцох

Улсын агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгийг

12.1 Нислэгийг гүйцэтгэгч улсын агаарын хөлөг үндсэн аэродром дээр эргэж ирснээр,

12.2 Нислэгийг захиалагч нь аяллын зорилгоо биелсэн тухай улсын агаарын хөлгийг эзэмшигч болон үйлчлэгч бусад байгууллагуудад албан ёсоор мэдэгдсэнээр тус тус дууссанд тооцно.

--oOo--

ХЯНАЛТАЙ ХУВЬ  
2020-05-12  
ААЧБХ